



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/239
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
ГАЗРЫН ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 4,194.2 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аар 4 төрлийн хэмжилтийн хүсэлтийг авч, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд шуурхай хүргэж эхэлсэн байна.

Агаар бохирдуулах бодисыг автомат багажаар тодорхойлоход өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад PM2.5 тоосонцор нь 13-19 хувиар, азотын давхар исэл (NO2) нь 27 хувиар тус тус багасаж, харин хүхэрлэг хий (SO2) нь 37 хувиар ихэссэн үзүүлэлттэй байна.

Тайлант онд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд Таван толгой түлш ХХК-ээс эцсийн борлуулалтын цэг, агуулах хүртэл нийт 560,670 тонн сайжруулсан шахмал түлш тээвэрлэх ажлыг зохион байгуулж 21,847.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, нөөцийн хадгалах агуулахад 4,998.1 сая төгрөг шилжүүлж, 582 байршилд шахмал түлш борлуулалтын цэг ажиллуулан гэр хорооллын 203,683 айл өрхөд ханган нийлүүлж, борлуулалтын урамшуулалд 7,151.9 сая төгрөг зарцуулсан байна.

"Ногоон технологи-2024" үзэсгэлэнг зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн суваг, үүрэн телефоны байгууллагатай хамтарч агаарын бохирдол хүний эрүүл мэнд хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах зөвлөмж, шторк, видео, контент бэлтгэж, 3 төсөл, 2 өдөрлөг зохион байгуулж 15 мянга гаруй иргэд оролцуулсан, зөвлөмж сэрэмжлүүлэх бүхий тараах материал хэвлүүлж, 2 сая гаруй иргэдэд хүргүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг системд мэдээлээгүй, захиалга хүргүүлээгүй, худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй, шатахуун зарцуулалтын тайланд зохистой менежмент хэрэгжүүлээгүй байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн хэрэгжилт 88.7 хувиар үнэлэгдэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


М.ЭРДЭНЭЖАРГАЛ